



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 312

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа Нийгмийн даатгалын зарим хэлтсүүдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 89,800,000.00 (наян есөн сая найман зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 3 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригт, холбогдох Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;


2.3. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002045



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн
372 дугаар тооллын хавсралт

Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа
Нийгмийн даатгалын зарим хэлтсүүдийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах автомашин

Д/д	Автомашинь марк, улсын дугаар, арал	Үлдвэрсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан эзлэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргэн босголын зардал (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)	Балансад бүртгэлтэй байгуулла гын нэрс
1	Ландкрузер-80, 18-18 ХОА, арал №ННЗJ810004245	1995/ 2011	135500	34,900,000.00	34,900,000.00	0	0	1,500,000.00	375,000.00	Ховд аймгийн НДХ
2	Тоеота кроун 56-78 УНГ, арал №4Т1BE46K97U10 6567	2004/ 2012	157288	20,000,000.00	20,000,000.00	0	0	1,500,000.00	375,000.00	Чингэлтэй дүүргийн НДХ
3	Ландкрузер-80, 59-05 ӨМҮ, арал №ННЗJ810004245	1993/ 2012	148671	34,900,000.00	34,900,000.00	0	0	1,500,000.00	375,000.00	Өмнөговь аймгийн НДХ
	Нийт дүн			89,800,000.00 (нааян есөн сая найман зуун мянган)	89,800,000.00 (нааян есөн сая найман зуун мянган)	0	0	4,500,000.00 (дөрвөн сая таван зуун мянган)		